

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Төв чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 243 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт байгууллагын батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Төв чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ (Ц.Батсүх)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 153 дугаар тогтоолын хавсралтын 1,2,5 дугаар мөрөнд заасан Төсөвт байгууллагын тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 3-7 дугаар мөрөнд заасан Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

**ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Төв аймгийн Зуунмод сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		Төг/м³	3,600.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	57,839.0
		Тогтмол	Төг/м³	1,107.0
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		Төг/м³	2,150.0
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	41,193.0
		Тогтмол	Төг/м³	1,069.0
5	Төсөв, ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м³	5,370.0
			Төг/хүн	6,270.0
6	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, “00”-ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м²	1,400.0
7	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м³	1,820.0
			Төг/хүн	2,740.0

--oOo--